

# МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Нийгэм судлал 10-р анги

II улирал.

[Email: D.Urantsetseg@must.edu.mn](mailto:D.Urantsetseg@must.edu.mn)

# ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Монгол улсад ардчиллын үнэт зүйлс хэрхэн хэрэгжиж байгаа талаар асуулт дэвшүүлж ярилцах.
- Баримт мэдээлэл, жишээ, тохиолдлыг цуглуулан шинжлэх
- Мэдээллүүдийг тодорхой аргууд ашиглан/вен диаграмм, хүснэгтийн, график/харьцуулж дүгнэлт хийх, тэмдэглэл хөтлөх

# ТУЛГУУР ОЙЛГОЛТ


- **Авлига** гэж албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ.
- **Ашиг хонжоо** гэж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ.
- **Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах** гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг хэлнэ.

# МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Эх сурвалж: "Ардчилал бидэнд юу өгсөн бэ" сэдэвт онол, практикийн хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын хэлсэн үг.

“Ардчилсан хувьсгал ялснаас хойших 30 жилд Монголын нийгэм цөөнгүй бэрхшээлтэй учирч байсан ч ардчиллаас хэзээ ч үл ухран, ардчиллын үнэт зүйлсийг өөрсдийн итгэл үнэмшил, амьдрах ажиллах орчноо болгон төлөвшүүлж чадсан нь өнгөрсөн он жилүүдийн гол ололт амжилт мөн. Ололтын хажуугаар алдаа эндэгдэл ч бас оршиж ирлээ.Олигарх-цөөнх нийтийн баялагт хяналтаа тогтоон, үр шимийг нь сорон мөлжиж, баялгийн эзэд болох ард түмэн хоосон үлдсэн нь өнгөрсөн жилүүдийн том сургамж мөн.” гэдгийг дурджээ.

# МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС (2015-2018ОН)



## Даалгавар-1

Ардчилалын үнэт зүйлсийн хэрэгжилтэнд үнэлэлт өгнө үү.

		2006	2010	2014
1. Эрх зүйт ёс	<u>Гэмт хэрэгт холбогдсон түшигдүүдийг шүүх ямагт шийтгэдэг</u>	62.7	27.6	42.8
	<u>Хууль сахидаг</u>			
засаг	<u>Төр засгийн хан хууль зөрчиж, эрх мэдлээ хэтрүүлдэг</u>	24.7	18.9	25.3
	Орон нутгийн удирдлагын түвшин дэх авлигын тархалт	47.5	40.6	47.4
Авлигын				
хяналт	Төр засгийн дээд түвшин дэх авлигын тархалт	22.1	15.7	25.2
	Авлигыг таслан зогсоох төр засгийн чармайлт	51.2	35.1	51.9
2. Өрсөлдөөн	Намуудаас сонголт хийхэд сонгууль хэр боломж олгодог вэ?	48.4	36.6	43.5
	Сонгуулийн үеэр ХМХ намуудыг адил сурталчилдаг	62.5	78.3	79
	Сонгууль хэр чөлөөтэй, шудрага явагддаг вэ?	66.8	67.6	86.1
3. Оролцоо	Сонгуульд санал өгч оролцсон байдал	83.5	85.7	89.1
	Сонгуулийн кампанит ажилд хамрагдсан байдал	60.8	51.7	55.6
	Тодорхой нэр дэвшигчийг дэмжиж бусдыг ятгасан байдал	31.4	35.3	31.7

Эх сурвалж:  
Д.Ганбат. Монгол дахь ардчилал ба түүний чанар судалгаа

## Даалгавар-2

Дараах эсээг уншаад санал бодлоо бичнэ үү?

...Тийм ээ, бидний өмнө ардчиллыг төлөвшүүлэх, алдаа оноог нь засаж төгөлдөржүүлэх шаардлага урган гараад байгааг ард түмэн ч, улс төрчид ч хүлээн зөвшөөрч, үүнд анхаарал хандуулж эхлээд байгаа нь сайн хэрэг юм. Ардчиллын гол мөн чанар нь ард иргэдийн амар амгалан, аз жаргалтай амьдралын үндэс байхад оршино. Ерөөс тэдний эрх чөлөө, эв нэгдэл, сайн сайхан амьдралынхаа төлөө өөрсдөө үүсгэн бий болгосон үнэт зүйл билээ. Хэрэв дээрх гол мөн чанараасаа гажсан тохиолдолд зөв голдрилд нь оруулах үүрэг ч мөн ард иргэдэд бий...

Эх сурвалж: “Ардчилал миний хувьд” эсээ уралдааны ялагч Б.Алтанзул 2015он

## Даалгавар-3

# Жендер “Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх” сэдвээр бичил судалгаа хийгээрэй.

**Бичил судалгаа хийх дараах алхмуудыг санал болгож байна.**

- 1 Сэдэв сонголт. Доорх сэдвүүдээс нэгийг сонгож авах, сэдэв сонгосон үндэслэлээ бичих
- 2 Судалгааны зорилго. Ямар зорилгоор уг судалгааг хийж байгаагаа бичих
- 3 Судалгааны аргаа сонгох. Асуулга, ажиглалт, баримт бичиг мэдээлэлд судалгаа хийх, сурвалжлага г.м
- 4 Судалгааны төлөвлөгөө гаргах. Судалгааны хүрээнд хийх ажлуудаа төлөвлөнө
- 5 Мэдээлэл цуглуулах. Мэдээллийн олон эх сурвалжтай ажиллах, гадаад хэл дээр мэдээлэл олохыг эрмэлзэх
- 6 Мэдээлэлд боловсруулалт хийх. Мэдээллээс чухлыг нь ялгаж, боловсруулалт хийх, мэдээллийн технологийн чадвараа ашиглан танилцуулга бэлтгэх
- 7 Судалгааны тайлан хамгаалах. Өөрийн судалгааны үр дүнг танилцуулах
- 8 Сурч мэдсэнээ дүгнэх. Судалгаа хийх даалгаврын үр өгөөжийг дүгнэх, ямар чадваруудаа хөгжүүлсэн, цаашид хэрхэн сайжруулах талаар саналаа хэлэх



## ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Даалгавар 1,2,3-г дэвтэртээ хийгээрэй.
- 2.“Монгол дахь ардчилал”эсээ бичих
3. Сурах бичгийн 106-109 хуудсыг сайн уншиж судлаарай.